



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/151

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3.3, 30.3.4 дэх заалт, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг орон нутагт хэрэгжүүлэх, шаардлагатай зөвлөмж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Нийгмийн салбарын төслийн удирдагч)

Гишүүд: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
(Эрүүл мэндийн газрын дарга)
(Боловсролын газрын дарга)
(Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга)
(Цагдаагийн газрын дарга)
(Онцгой байдлын газрын дарга)
(Насан туршийн суралцахуйн төвийн захирал)
(Хөтөлбөрийн зөвлөх)

Нарийн бичгийн дарга: (Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллах төлөвлөгөө батлуулан, хагас, бүтэн жилийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж, холбогдох байгууллагад цаг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Алтангэрэл), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:zahiramjZax ZD 2025

8000010050